

**1 Япон Улсын Нийтийн Тэтгэврийн системийн талаарх Чухал Мэдээллүүд: Үндэсний Тэтгэврийн систем**

- (1) Япон улсад оршин суухаар бүртгүүлсэн, 20-59 насны бүх хүмүүс иргэний харъяалалаас үл хамааран Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж, хуулийн дагуу шимтгэл төлөх үүрэгтэй.
- (2) Нийтийн тэтгэврийн систем (Үндэсний Тэтгэврийн системийг багтаагаад) нь санхүүгийн өөр хоорондын дэмжлэг бүхий тогтолцооноос бүрддэг.
- (3) Нийтийн тэтгэврийн систем нь өндөр настны тэтгэврээс гадна хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны халамжийн тэтгэврийг хамардаг.
- (4) Япон улсын засгийн газраас тэтгэврийн тэтгэмжийн сангийн зарим хэсгийг санхүүжүүлдэг.
- (5) Таны нийтийн тэтгэврийн шимтгэлийг “нийгмийн даатгалын шимтгэл” гэх ба энэ нь татварын суутгалаас хамааран өөрчлөгдөнө.

**2 Сар бүрийн шимтгэл**

Үндэсний тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ нь 2026 оны 4-р сараас 2027 оны 3-р сар хүртэл нэг сард ¥17.920 байна.

Та шимтгэлээ банк, бусад санхүүгийн байгууллагууд, шуудангийн салбар болон 24 цагийн дэлгүүрт бэлнээр төлөх боломжтой. Түүнчлэн та банкны автомат гуйвуулга, интернэт төлбөр тооцоо эсвэл кредит карт ашиглан төлөх боломжтой.

**3 Үндэсний тэтгэврийн тэтгэмжүүд****(1) Өндөр настны үндсэн тэтгэвэр**

Хэрэв та дор хаяж 10 жилийн турш Үндэсний тэтгэврийн шимтгэл төлсөн бөгөөд холбогдох шаардлагыг хангаж буй тохиолдолд, та 65 нас хүрээд өндөр настны Үндсэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**(2) Хөдөлмөрийн чадвараа алдсаны үндсэн тэтгэвэр**

Хэрэв та Үндэсний тэтгэврийн системд хамрагдаж байх хугацаандаа өвчилсөн эсвэл гэмтсэний улмаас тухайн өвчин эсвэл гэмтэл нь 1 эсвэл 2-р зэргийн хөдөлмөрийн чадвар алдалтанд заасан хөдөлмөрийн чадвар алдалтыг үүсгэсэн тохиолдолд, та хөдөлмөрийн чадвараа алдсаны үндсэн тэтгэврээ тогтоолгох эрхтэй.

**(3) Тэжээгчээ алдсаны Халамжийн үндсэн тэтгэвэр**

Үндэсний тэтгэврийн системд хамрагдсан иргэн нас барахад хүүхдээ асарч үлдсэн гэр бүлийн хүн эсвэл хүүхдүүд нь Халамжийн үндсэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, өөрийн оршин суугаа орон нутгийн Үндэсний тэтгэврийн хэсэг эсвэл Япон улсын Үндэсний тэтгэврийн үйлчилгээний салбар оффист хандана уу.

Япон улсын Үндэсний тэтгэврийн үйлчилгээний вэб сайт <https://www.nenkin.go.jp/international/index.html>

**Япон Улсын Тэтгэврийн Үйлчилгээ** Дарах

Тэтгэвэрт хамрагдах талаар ерөнхий мэдээлэл авахын тулд, доорх утсаар бидэнтэй холбогдоно уу:

“Nenkin Kanyusha Dial” 0570-003-004 (дотоодод хямдралтай тарифаар)

Хэрэв таны утасны дугаар 050-аар эхэлсэн бол, доорх дугаарт залгана уу:

(Токио)03-6630-2525 (энгийн тарифаар)

Ажиллах цаг: 8:30-19:00 Даваа-Баасан

9:30-16:00 сар бүрийн хоёрдахь Бямба гараг

\* Баярын өдрүүдэд ажиллахгүй (сар бүрийн хоёрдахь Бямба гарагаас гадна), 12-р сарын 29-нөөс 1-р сарын 3 хүртэл

Япон улсад оршин суухаар бүртгүүлсэн, 20-59 насны бүх хүмүүс иргэний харъяалал, эсвэл оршин суух хугацаанаас үл хамааран Япон улсын нийтийн тэтгэврийн систем болох Үндэсний Тэтгэврийн системд хамрагдаж, хуулийн дагуу шимтгэл төлөх үүрэгтэй. Хэрэв та оюутан бөгөөд шимтгэл төлөхөд санхүүгийн бэрхшээлтэй тулгарсан бол та оюутнуудад зориулсан тусгай төлбөрийн системд хамрагдах өргөдөл гаргах боломжтой. Таны өмнөх жилийн орлого тодорхой хэмжээтэй тэнцүү эсвэл түүнээс бага байвал, шимтгэл төлөлтийг хойшлуулах өргөдөл гаргаж болно. (Энэхүү өргөдлийг жил бүр гаргах шаардлагатай.) Энэхүү үйл явцыг дагаснаар та ирээдүйд өндөр настны тэтгэвэр болон санамсаргүй байдлаар гэмтэж, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр авах шаардлагад багтсан даатгалын хүчинтэй хугацааг бий болгож буй болно.

**<Шаардлага хангасан оюутан гэж хэн бэ>**

Японы их дээд сургууль (бакалаврын дараах сургуулийг оролцуулан), коллеж, ахлах сургууль, технологийн коллеж, тусгай мэргэжлийн сургууль болон бусад сургуулиудад \*сурдаг, өмнөх жилийн орлого нь тодорхой хэмжээтэй тэнцүү буюу түүнээс бага эсвэл ажилгүй болсон оюутан.

\* Бусад сургууль → Сургуулийн боловсролын тухай хуульд заасан 1 ба түүнээс дээш жил сурах хугацаатай курсууд (зарим гадаад дахь их, дээд сургуулиудын Япон дахь салбар сургуулиуд мөн хамрагдах боломжтой. Дэлгэрэнгүйг Үндэсний тэтгэврийн салбар оффисоос лавлана уу.)

**Өргөдөл дээрх тэмдэглэлүүд****• Өргөдөл гаргаж буй жил**

- Чөлөөлөлт эсвэл хойшлуултанд хамрагдах жил нь 4 сард эхэлж, дараа жилийн 3-р сард дуусна.

- Хэрэв та дараагийн жилд чөлөөлөлт эсвэл хойшлуултанд үргэлжлүүлэн хамрагдахыг хүсвэл жил бүрийн 4-р сард өргөдлөө гаргах шаардлагатай.

**• Өнгөрсөн жил болон энэ жилийн өргөдөл**

- Өнгөрсөн жилүүдийн хувьд..... Та өргөдөл гаргасан огнооноос өмнөх өнгөрсөн 25 сарыг нөхөж чөлөөлөлт эсвэл хойшлуултанд хамрагдах(тухайн 25 сарын хугацаанд тодорхой саруудад аль хэдийн шимтгэл төлсөн бол, төлөгдсөн шимтгэл чөлөөлөгдөхгүй)өргөдөл гаргах боломжтой.

- Энэ жилийн хувьд: Та энэ жил чөлөөлөлт эсвэл хойшлуултанд хамрагдах өргөдөл гаргахад энэ нь дараа жилийн 3-р сар хүртэлх хугацааг хамарна. Нэг өргөдөл 4-р сараас дараа жилийн 3-р сар хүртэлх 12 сарыг хамарна. Хэрэв та удаан хугацааны чөлөөлөлтөнд хамрагдахыг хүсвэл нэгээс илүү өргөдөл бэлтгэх шаардлагатай.

**Жич:** Та өргөдөл гаргасан огнооноос өмнөх өнгөрсөн 25 сарыг нөхөж өргөдөл гаргах боломжтой. Өнгөрсөн даатгалын хугацааг хүчинтэй болгохын тулд өргөдлөө аль болох эрт гаргахыг бид танд зөвлөж байна. Хэрэв таны өргөдөл хойшлосон тохиолдолд та хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авах эрхгүй болж болзошгүй.

**• Бидэнд шаардлагатай бичиг баримтууд**

- Сурах хугацаа бичигдсэн оюутны үнэмлэхний “GAKUSEISHO” нэг эсвэл хоёр талын хуулбар (A4 хэмжээтэй) эсвэл элсэлтийн гэрчилгээний “ZAIGAKUSHOMEISHO” эх хувь, сурах хугацаа (элсэн орсон огноо болон төгсөх хугацаа), анги болон оюутны үнэмлэхний дуусах хугацаа бичигдсэн .

- Хэрэв та ажилгүйдэл, дампуурал эсвэл бизнесээ зогсоосноос шалтгаалан чөлөөлөлтөнд хамрагдах өргөдөл гаргаж буй тохиолдолд, таны хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн гэрчилгээ (Koyohoken Jikyu Shikakusha Sho) эсвэл хөдөлмөр эрхлэлтийн даатгалд даатгуулагчийн цуцлалтын баримтын (Koyohoken Hihokensha Rishokuhyou) аль нэгний хуулбар зэрэг холбогдох нотлох бичиг баримт шаардлагатай. Шаардлагатай нотолгооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд, өөрийн оршин суугаа орон нутгийн үндэсний тэтгэврийн оффис эсвэл үндэсний тэтгэврийн салбар оффист хандана уу.

**• “Хувийн дугаар” ашиглан төрөл бүрийн өргөдөл гаргах тохиолдолд**

- Хэрэв та манай оффист өргөдөл гаргах бол Хувийн дугаартай үнэмлэхээ авчрах хэрэгтэй. Хэрэв танд уг үнэмлэх байхгүй бол доорх (1) ба (2) дугаарт дурьдсан бичиг баримтуудыг авчирна уу.

- Хэрэв өргөдлөө шуудангаар илгээх бол “Хувийн дугаар”-тай үнэмлэхнийхээ нүүр ба ар тал тус бүрийн хуулбар эсвэл (1) ба (2) дугаарт дурдсан бичиг баримтуудын хуулбарыг хавсаргана уу.

(1) Таны “Хувийн дугаар”-ыг харуулсан оршин суух бүртгэлийн баталгаажуулсан хуулбар, эсвэл “Хувийн дугаар” олгосныг баталгаажуулсаналбан бичиг (таны оршин суух бүртгэл дээрх нэр ба хаяг ижил тохиолдолд).

(2) Таны жолооны үнэмлэх, паспорт, оршин суугчийн үнэмлэх, эсвэл таныг “Хувийн дугаар”-ын жинхэнэ эзэмшигч болохыг баталгаажуулсан, дээрхтэй дүйцэхүйц бичиг баримт (Дэлгэрэнгүйг Тэтгэврийн байгууллагын салбараас лавлана уу.)

**ӨРГӨДЛИЙГ ХААНА ГАРГАХ ВЭ**

• Өргөдлийг өөрийн оршин суугаа орон нутгийн оффис эсвэл үндэсний тэтгэврийн салбар оффист өгнө үү. Мөн өргөдлөө шуудангаар илгээж болно.

• Хэрэв танай сургууль өргөдөл гаргахад туслах Оюутны үндэсний тэтгэврийн шимтгэл чөлөөлөлт/ хойшлуулалтыг хариуцсан хуулийн этгээдтэй “GAKUSEI NOFU TOKUREI JIMU HOJIN” бол та шилжүүлж болно. Сурч буй сургуулиасаа лавлана уу.

• Бөглөсөн өргөдлийнхөө 3 дахь хуудсыг та өөртөө авч, хадгална уу.

**Өргөдлийн маягыг хэрхэн бөглөх талаар дараах хуудаснаас харна уу.**

① -д 12 оронтой "Хувийн дугаар" (Япон дахь таны хувийн дугаар) эсвэл 10 оронтой үндсэн тэтгэврийн дугаараа оруулна уу. (Үндсэн Тэтгэврийн Дугаарыг зүүн талд буй хэсэгт оруулна уу.) (Үндсэн тэтгэврийн дугаарын хувьд зүүн талд зэрэгцүүлсэн дугаарыг оруулна уу.)

③-д нэрээ оруулна уу.

Төлбөрийн тусгай систем (төлбөрийг хойшлуулах) олгохыг хүссэн жилээ

⑤-д оруулна уу.  
Өргөдөл гаргах нэг жил нь 4-р сараас 3-р сарыг хамарна. Жишээлбэл, хэрэв та 2026 онд өргөдөл гаргавал 2026. 4. болон 2027. 3 гэж оруулна уу.

Та 20 ба түүнээс дээш настай, тухайн хугацаанд оюутан байх тохиолдолд өргөдөл гаргасан өдрөөс өмнөх 25 сар хүртэлх хугацааг нөхөж өргөдөл гаргаж болно. Харин 25 сарын хугацаанд зарим саруудад шимтгэл төлсөн бол төлсөн шимтгэлийг нөхөн олгохгүй.

Их сургууль, сургуульд элсэн орсон жил/сар болон хүлээгдэж буй төгсөлтийн жил/сарыг ⑥-д оруулна уу.

«ЧУХАЛ» Өргөдөл гаргасан жилийн өмнөх жилийн орлогоо ⑪-д бичнэ үү. 1. Орлогогүй бол 2. Орлого нь ¥ 1,280,000 ба түүнээс бага бол, 3. Орлого нь ¥ 1,280,000-аас дээш бол гэж дугуйлна уу.

Жич: Орлого гэдэг нь Япон дахь орлогоосоо шаардлагатай зардлыг хассан гэсэн үг. Хэрэв та татвараа төлөөгүй эсвэл мэдэхгүй байгаа бол өөрийн оршин суугаа хотын захиргаанаас лавлана уу.

Хэрэв та өргөдөл гаргах жилийн хугацаанд ⑤-д нүүж ирсэн бол ⑬-д нүүж ирсэн улсынхаа огноо, нэрийг оруулна уу. Жишээлбэл, хэрэв та 2026 оны 4-р сарын 1-нд АНУ-аас Япон руу нүүсэн бол "АНУ-аас 2026 оны 4-р сарын 1-нд нүүсэн" гэж оруулна уу.

ГAKYUSEIHO" оюутны үнэмлэхний нэг буюу хоёр талын цээж зураг (A4 хэмжээтэй цаас) эсвэл сургуульд хамрагдсан хугацаа (элссэн болон төгсөх хугацаа), дүн, оюутны үнэмлэхний хүчинтэй хугацаа зэргийг харуулсан "ZAIGAKUSHOMEISHO" оюутны үнэмлэхний эх хувийг ирүүлнэ үү.

Маягтын эхний хэсэгт та өргөдөл гаргагчийн хувиар төлбөрийн тусгай системд хамрагдахаар өргөдөл гаргаж буйгаа дурдана уу. Мөн, таны талаарх мэдээлэл болон өмнөх жилийн орлогын мэдүүлэг бүрэн бөгөөд үнэн зөв гэдгээ та энд баталж байна. Таны өргөдлийг шалгахад шаардлагатай хувийн мэдээллийг Япон Улсын Тэтгэврийн Үйлчилгээ (JPS) болон түүний орон нутгийн оффистой хуваалцахыг та зөвшөөрч, тэдэнд эрх олгож байна.

Энэ нь оюутны тэтгэврийн шимтгэлийн төлбөрийн тусгай системд хамрагдах өргөдлийн маягт юм

国民年金保険料学生納付特例申請書

日本年金機構理事長 へて 令和 2026 年 4 月 1 日

以下のとおり学生納付特例を申請します。また、前年所得の記入内容に誤りがないことを申し立てします。この申請に必要な本人に関する情報(所得情報、生計保護受給情報等)の確認に、日本年金機構に委託

〒 123 - 4567  
TOKYOTO, SUGINAMIKU, TAKAIDONISHI, 1-2-3

住所: JOHN SMITH  
被保険者氏名: JOHN SMITH

基本情報

① 個人番号 (または基礎年金番号)	XXXXXXXXXX	② 生年月日	1990 年 8 月 10 日
③ 氏名	JOHN SMITH	④ 電話番号	080 - XXXX - XXXX

ハムラгдах жил

申請期間 (学生納付特例を受けようとする期間) 平成 2026 年 4 月から 平成 2027 年 3 月まで

在学予定期間 平成 2026 年 4 月から 平成 2029 年 3 月まで

⑦ 学校の名称 ABC University

⑧ 学校の所在地 TOKYOTO 都 府 県 SUGINAMIKU, XX-CHO

⑨ 学生の区分 ① 学生 (学位あり) ④ 研究生 ② 通信制・通信課程 ⑤ その他 ③ 科目履修生

⑩ 学生証の有効期限 平成 2027 年 3 月まで

⑪ 前年所得 ① なし ② あり (128万円以下) ③ あり (128万円超) ⇒ 16歳以上19歳未満の扶養親族 【あり (人) ・ なし】

⑫ 特例認定区分 (申請書) 1. 失業 平成 2026 年 4 月 1 日 ⇒ 雇用保険加入 あり ・ なし 2. 天災等 3. その他 ( )

⑬ 備考 2026 年 4 月 1 日 1-nd 度 АНУ-с нүүн шилжсэн

Өргөдөл гаргасан огноо (он/сар/өдөр), өргөдлийн огнооны хаяг, өөрийн нэрээ англи цагаан толгойн үсгээр паспорт дээр харуулсны дагуу оруулна уу.

②-д төрсөн огноогоо (он/сар/өдөр) оруулна уу.

④-д утасны дугаараа оруулна уу. Холбогдох утасны төрлийг дугуйлна уу;  
1. гэрийн утас, 2. гар утас, 3. ажлын байрны утас, 4. бусад утас.

Их сургууль, сургуулийнхаа нэрийг ⑦-д оруулна уу.

⑧-д муж, хот, сууринг оруулан их сургууль, сургуулийнхаа хаягийг оруулна уу.

⑨-д хамрагдах оюутнуудын ангиллын дугуйланг  
1. оюутанд (төгсөхдөө эрдмийн зэрэг олгох), 2. захидлын ангид, 3. кредит аудитор "KAMOKU RISHUSEI", 4. эрдэм шинжилгээний ажилтанд, 5. бусад хүмүүст.

Боломжтой бол оюутны үнэмлэхний хугацаа дуусах он сарыг ⑩-д оруулна уу.

Хэрэв та ажилгүй болсон, тухайлбал ажлаас халагдсан гэх шалтгаанаар тусгай төлбөрийн системд хамрагдах хүсэлт гаргасан бол ажлаас халагдсан өдрийн дараагийн огноог (он/сар/өдөр) ⑫-д оруулна уу.  
Хэрэв та ажлаасаа халагдахаасаа өмнө хөдөлмөрийн даатгалд хамрагдаж байсан бол ⇒ суман тэмдгийн баруун талд "あり" (тийм) гэж дугуйлж, даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийг ирүүлнэ үү. Хэрэв хамрагдаагүй бол "なし" (үгүй) гэж дугуйл. (Тодорхой баримт бичгийг 1-р хуудаснаас үзнэ үү)

※ 所得に関する情報について、関係法令に基づき、申告義務がある場合には、正しく申告する必要があります。

市区町村確認欄 学生証確認済

【留意事項】  
○ 学生証のコピーを A4判で添付してください。  
○ 学生証裏面に有効期限、学年、入学年月日の記載がある場合は裏面のコピーも必要です。  
○ 在学証明書を添付される場合は、学生証のコピーは必要ありません。